



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 54

Мандалговь

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 81 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 4 дүгээр зүйлийн 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арванзургаадугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хулд суманд барьж, ашиглалтад оруулсан нийт 1,240,781,830 /нэг тэрбум хоёр зуун дөчин сая долоон зуун наян нэгэн мянга найман зуун гуч/ төгрөгийн өртөгтэй барилга байгууламжийг Хулд сумын Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөд хавсралтын дагуу бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хулд сумын Эрүүл мэндийн төвийн дарга (Б.Мөнхшүр)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;


2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2023 оны 12 дугаар сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.ОД-ЭРДЭНЭ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн
54 дугаар тогтоолын хавсралт



Хулд сумын Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөд
бүртгэх хөрөнгийн мэдээлэл

№	Хөрөнгийн нэр	Биет хэмжээ	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Эмнэлгийн барилга	2885	1	1,072,759,459	1,072,759,459
2	Гадна гэрэлтүүлэг	220 квт	6	2,393,238	14,359,428
3	Халаалтын зуухны тоног төхөөрөмж	6.3м3/ц	1	72,805,916	72,805,916
4	Авто машины зогсоол	306м2	1	32,598,484	32,598,484
5	Явган хүний зам	453м2	1	48,258,543	48,258,543
	Нийт хөрөнгийн дүн				1,240,781,830 /нэг тэрбум хоёр зуун дөчин сая долоон зуун наян нэгэн мянга найман зуун гуч/ төгрөг